



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 02/32-01

Сүхбаатар сум

Зөрчил арилгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь аймгийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн ДА-2026/08/ҮА дугаартай удирдамжийн дагуу Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн 2024-2025 оны үйл ажиллагаанд хийсэн аудитаар Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 20 төсөл, арга хэмжээний төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийлгүйгээр Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулсан зөрчил илэрлээ. Үүнд:

- Аудитаар 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас (ОНХС) санхүүжих 600,000,000 (Зургаан зуун сая) төгрөгийн өртөгтэй 5 төсөл арга хэмжээ;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар (ОНХС) хэрэгжүүлэх 5,294,247,000 (Таван тэрбум хоёр зуун ерэн дөрвөн сая хоёр зуун дөчин долоон мянга) төгрөгийн 12 төсөл төсөл арга хэмжээ;
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх 209,000,000 (Хоёр зуун есөн сая) төгрөгийн 2 төсөл арга хэмжээ;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1,500,000,000 (Нэг тэрбум таван зуун сая) төгрөгийн 1 төсөл арга хэмжээ.

Нийт дүнгээр 7,686,247,000 (Долоон тэрбум зургаан зуун наян зургаан сая хоёр зуун дөчин долоон мянга) төгрөгийн төсөл, арга хэмжээг зураг төсөвгүйгээр төлөвлөсөн байна

Энэ нь төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг (Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан төслийг тусгах) болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3 дахь заалтыг (Зураг төсөвгүй төслийг төлөвлөгөөнд тусгахыг хориглох) тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг

4326007006

албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д “Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ.” гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах: 2027 оны төсвийг боловсруулахдаа шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ бүрийг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шалгуур (ТЭЗҮ, зураг төсөв, зөвшөөрөл)-ыг бүрэн хангуулсны үндсэн дээр төлөвлөж, батлуулах.
2. Дахин гаргахгүй байх: Төрийн худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, дээрх зөрчлийг дахин давтахгүй байх.
3. Хэрэгжилтийг тайлагнах: Албан шаардлагын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр ирүүлэхийг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Я.Мөрөн), мэргэжилтэн (С.Өлзийбүрэн) нарт даалгав.
4. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ

Т.ОДСҮРЭН



ЗӨВШӨӨРСӨН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БҮС ОРОН
НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Я.МӨРӨН

МЭРГЭЖИЛТЭН

С.ӨЛЗИЙБҮРЭН

